

ТАНИЛЦУУЛГА

Итгэлцүүр хэрэглэх журам батлах тухай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөл боловсруулсан тухай

2023 оны 11 дугаар сарын 27-ны өдөр

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн "Журам аргачлал батлах тухай" А/64 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг хэрэглэх журам"-д заасны дагуу итгэлцүүрийг хэрэглэж байна.

Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн "Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай" 238 дугаар тогтоолоор итгэлцүүрийг батлан одоо мөрдөж байна.

Дээрх тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг 2022 он суурьтайгаар баталж, тэтгэвэр тогтоох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд 1,404,000.0 (нэг сая дөрвөн зуун дөрвөн мянга) төгрөгөөр, мөн өдрөөс хойших хугацаанд Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооноос баталсан тухайн үеийн сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар баталж өгсөн.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход итгэлцүүр хэрэглэнэ", 22.2-д "Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө" гэж тус тус заасан.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэгт "Итгэлцүүрийг хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмыг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан.

Дээрх хуулийг хэрэгжүүлэх зорилгоор "Итгэлцүүр хэрэглэх журам батлах тухай" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төсөлд дараах агуулгыг тусган боловсрууллаа. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх харилцаанд итгэлцүүрийг хэрэглэх;
- Цалинд үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтооход итгэлцүүрийг хэрэглэх;

- Сарын цалин хөлсний дээд хэмжээг Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолын 3-д заасантай адил байхаар тусгасан;

- 2024 онд Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн тогтоох, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор баталсан тэтгэвэр бодоход баримтлах итгэлцүүрийг хэрэглэх, түүнээс хойших хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-д заасны дагуу баталсан итгэлцүүрийг хэрэглэх тусгасан;

- Нэрийн дансны гарааны үлдэгдэл тооцоход одоо хэрэглэж байгаа итгэлцүүр/индекс/-ийг журамдаа шууд тусгаж өгсөн болно.

Итгэлцүүр хэрэглэх журмын төсөлд Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 01/2037 дугаартай албан бичгээр санал ирүүлснийг тусгасан болно.

--- о О о ---

20 дугаар зүйл.Тэтгэвэр тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох

Хэвлэх

20.1.Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилд шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг 60-д хувааж бодно.

20.2.Даатгуулагч 5 жилээс доош хугацаанд шимтгэл төлсөн байх нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох тохиолдолд тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлохдоо шимтгэл төлсөн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нийлбэрийг түүний шимтгэл төлсөн нийт сарын тоонд хувааж бодно.

20.3.Цалинд үндэслэсэн аргаар өндөр насны, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоохдоо даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22.2-т заасны дагуу тогтоосон итгэлцүүр хэрэглэнэ.

20.4.Даатгуулагчийн тэтгэвэр тогтоолгохоор сонгосон дараалсан жилийн сар бүрийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ нь тухайн үед мөрдөж байсан нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

20.5.Даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох 1995 оноос өмнөх хугацааны цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нь архивын, эсхүл санхүүгийн баримтаар нотлогдох боломжгүй тохиолдолд тэтгэврийн хэмжээг үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг баримтлан бодно.

20.6.Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзан хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.7.Тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг тодорхойлох, хэрэглэх журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална

19.4.Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээ нь албан журмаар даатгуулагчийн хувьд тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, сайн дураар даатгуулагчийн хувьд 7 дахин нэмэгдүүлсэнтэй тус тус тэнцүү байна.